



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар

А/Н/1


Улаанбаатар хот

«Улаанбаатар хотын аварга шалгаруулах»  
Н.Намжил багшийн нэрэмжит өсвөрийн шатарчдын  
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тус тус үндэслэн ТУЦААХ нь:

1. Улаанбаатар хотын 2018 оны аварга шалгаруулах Н.Намжил багшийн нэрэмжит өсвөрийн шатарчдын тэмцээнийг 2018 оны 10 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд "Зууны шатар" клубт зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.890.000 /Нэг сая найман зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Спортын уралдаан, тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2018 оны 09 сарын  
14-ны өдрийн 14 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах  
Н.Намжил багшийн нэрэмжит өсвөрийн шатарчдын  
тэмцээн зохион байгуулах зардлын төсөв

№	Зардлын нэр	Нийт зардал /төг/
1.	Тамирчдын шагнал: 12 x 20.000 төг = 240.000 төг 12 x 15.000 төг = 180.000 төг 36 x 10.000 төг = 360.000 төг	780.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: 10 хүн x 2 өдөр x 20.000 төг	400.000
3.	Диплом / өргөмжлөл	50.000
4.	Медаль	600.000
5.	Анонс/цом/бичлэг	60.000
	Дүн	1.890.000



Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2018 оны 09 дугаар сарын  
11-ны өдрийн 11 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН 2018 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
Н.НАМЖИЛ БАГШИЙН НЭРЭМЖИТ ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН  
ТЭМЦЭЭНИЙ ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДХҮҮН

- |     |                    |                |
|-----|--------------------|----------------|
| 1.  | Ерөнхий шүүгч      | П.Жигжидсүрэн  |
| 2.  | Нарийн бичиг шүүгч | С.Ган-Од       |
| 3.  | Шүүгч              | Г.Даваахүү     |
| 4.  | Шүүгч              | Ч.Бадрах       |
| 5.  | Шүүгч              | Д.Хишигдорж    |
| 6.  | Шүүгч              | Н.Наранцэцэг   |
| 7.  | Шүүгч              | Б.Галсанбаатар |
| 8.  | Шүүгч              | Ч.Мөнхбат      |
| 9.  | Шүүгч              | А.Баярсайхан   |
| 10. | Шүүгч              | Н.Нямтэмүүлэн  |